

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ 2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР/ПҮРЭВ
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	2-23
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	24-100
	1.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/	24-45
	2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл /Засгийн газар 2019.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	45-53
	3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 2 гишүүн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	53-59
	4.Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл /Засгийн газар 2019.11.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	59-65
	5.Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл /Засгийн газар 2020.01.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	65-100

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 43 гишүүн ирж, 57.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 00 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Гарамжав, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат, Б.Наранхүү, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Энхтүвшин, С.Эрдэнэ, Ж.Эрдэнэбат;
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан, Б.Бат-Эрдэнэ, С.Батболд, Д.Ганболд, Я.Санжмятав, О.Содбилэг, Д.Тэрбишдагва, Ж.Энхбаяр;

Тасалсан: О.Баасанхүү, М.Билэгт, С.Жавхлан, Ц.Мөнх-Оргил, Н.Номтойбаяр;

Хоцорсон: О.Батнасан-1 цаг 00 минут, Г.Мөнхцэцэг-22 минут, Д.Сарангэрэл-30 минут, Д.Сумъяабазар-40 минут, Б.Ундармаа- 54 минут, Д.Цогтбаатар-1 цаг 30 минут, Н.Цэрэнбат-1 цаг 20 минут, Б.Энх-Амгалан-10 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Хаянхярваа, Д.Сумъяабазар нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, мөн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, референт Б.Золбоо нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Д.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Тогтоолын төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.Энэ тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 31
Татгалзсан 14
Бүгд 45
68.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Тогтоолын төслийн хавсралт /цаашид хавсралт гэх/-ын 1 дүгээр бүлгийн 1 дэх хэсгийн хүснэгтэд доор дурдсан агуулга бүхий мөр нэмэх:

2.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	• Төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгох.
----	--	---------	--

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 30
Татгалзсан 14
Бүгд 44
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Хавсралтын 1 дүгээр бүлгийн 1 дэх хэсгийн хүснэгтээс 2 дахь мөр, 3 дахь хэсгийн хүснэгтийн 5, 6 дахь мөр, 4 дүгээр бүлгийн хүснэгтээс 2 дахь мөрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 29
Татгалзсан 15
Бүгд 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Хавсралтын 1 дүгээр бүлгийн 1 дэх хэсгийн хүснэгтийн 4 дэх мөрийн “Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга” гэсэн баганын “Цөмийн энергийн тухай хуулийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмж Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх,” гэснийг “Хуулийн зохицуулалтыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын

хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 29
Татгалзсан 15
Бүгд 44

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн найруулгын санал.

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Нэг. Хавсралтын 1 дүгээр бүлгийн 1, 2, 3, 4 дэх хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах. *Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд хийсэн найруулгын засвар/*

“1.Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

1.1.Байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж (татвар, хураамж, ашиг г.м) –ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь Монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах;

1.2.Үндэсний баялгийн санг байгуулахдаа энэхүү сан нь хөгжлийн болон хуримтлалын сан байх, түүний хувьцаа эзэмшигчийн хувьд хөрөнгийг нь захиран зарцуулах чиг үүргийг Засгийн газар хэрэгжүүлэх, санд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны төлбөр, төрийн өмчийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого, газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүн хуваах гэрээний орлого, төрийн хувьцааны ногдол ашиг, сангийн хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх;

1.3.Сангийн хөрөнгийн удирдлагын компани сангийн хөрөнгийг удирдахдаа хараат бус, бие даан ажиллах, компанийн болон сангийн удирдлагын сайн засаглалыг хэвшүүлэх, сангийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх, түүний үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэддээ хүртээхдээ тэгш байдал, шударга ёсны зарчмыг дээдлэх, сангийн хөрөнгийн удирдлагын компанийн давуу эрхийн хувьцааны ногдол ашиг олгох;

1.4.Газрын хэвлийн баялаг ашигласны улмаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг хангах, байгалийн тэнцлийг хадгалах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none">• Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох;• Стратегийн ач холбогдолтой ордын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох;

			<ul style="list-style-type: none"> • Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох; • Онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, саналыг нь авч, тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах; • Ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хадгалах, нөхөн сэргээх уг үйл ажиллагаанд оролцогчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгох.
2.	-Байгаль орчны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбоотой зохицуулалтыг нэмэх.
3.	-Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Гадаадын улс орны цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох зохицуулалтыг тусгах.
4.	-Үндэсний баялгийн сангийн тухай хууль /анхдагч хууль/ -Засгийн газрын тусгай сангийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Газрын хэвлийн баялаг ашигласны орлогоос Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, түүнийг санхүүгийн үр ашиг бүхий төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, үнэт цаас гаргах зэргээр арвижуулах; • Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, шударгаар хуваарилах зарчмыг баримтлах; • Засгийн газрын тусгай сангийн зохицуулалтуудыг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нийцүүлэх.
5.	-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг баталгаажуулах; • Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг зөрчиж байгаа эсэхэд иргэдийн зүгээс хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоох.
6.	-Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох.

2.Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төсөв, санхүүтэй холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

2.1.Улсын Их Хурал цаг хугацааны шалгуурыг даах Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогыг батлахдаа нийгмийн зөвшилцлийг хангаж байх;

2.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог үндэсний түвшинд бүрдүүлэх, Засгийн газрын бүтцийн үндсэн нэгжийг байгуулах эрх зүйн үндсийг тогтоох;

2.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахдаа Хөгжлийн болон Үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх эрх зүйн үндсийг тогтоох;

2.4.Улсын Их Хурал жил бүрийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, харин төсвийн орлого, зарлагын бүтцийг хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчилж болохоор зохицуулах;

2.5.Төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;

2.6.Төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	2020 он	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах, төлөвлөлтийн байнгын, мэргэшсэн тогтолцоо бүрдүүлэх, бодлого төлөвлөлт нь дээрээсээ доош, доороосоо дээш чиглэх зарчмыг тодорхойлж, цаг хугацааны болон нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалсан орон зайн төлөвлөлт хийх механизмыг бүрдүүлэх; • Бодлого, төлөвлөлт нь судалгаанд үндэслэсэн байх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтвортой тогтолцоо бий болгох; • Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Засгийн газрын үндсэн бүтцийн нэгж бий болгох, уг нэгж нь улс төрийн сонгуулийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой ажиллах зохицуулалтыг бий болгох; • Бодлого боловсруулах, төлөвлөлт хийх хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх онцлог тогтолцоог бүрдүүлэх.
2.	-Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Улсын Их Хурал нь Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зардал болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн улсын төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болох зохицуулалтыг тусгах;

			<ul style="list-style-type: none"> • Жил бүрийн төсөв нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд суурилсан байх шаардлагыг хуульчлах; • Улсын Их Хурлаас төсвийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох.
3.	-Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Сонгуульд өрсөлдөх улс төрийн намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх шаардлагыг тусгах; • Энэхүү шаардлага хангагдаагүйгээс үүсэх хууль зүйн үр дагаврыг хуульчлах.
4.	-Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 он	<ul style="list-style-type: none"> • Төрийн аудитын байгууллагын бие даасан, үйл ажиллагааны хараат бус байдлыг сайжруулах, эрх хэмжээг нэмэгдүүлэх; • Зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх.

3.Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгож, хариуцлагыг сайжруулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

3.1.Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахдаа Үндсэн хууль зөрчсөнийг нь Үндсэн хуулийн цэц тогтоосон байхыг үндэслэл болгох;

3.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох зохицуулалтыг боловсронгуй болгох;

3.3.Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар эцэслэн батлах, Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр өгдөг үндсэн зарчмыг хадгалж, харин Үндсэн хууль болон бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол нууц санал хураалт явуулж байхаар өөрчлөх;

3.4.Хянан шалгах түр хороог хуулиар тусгайлан тогтоосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг арга хэрэгсэл ашиглан Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан эсэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор байгуулах, түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчлах;

3.5.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хууль санаачлах хүрээ, хязгаарыг хуулиар тогтоох;

3.6.Улсын Их Хурлын хууль тогтоомжийн төсөл хэлэлцэн батлах үйл ажиллагааны болон батлагдан гарч буй хууль тогтоомжийн чанарыг сайжруулах,

түүнчлэн хянан шалгах бүрэн эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын ээлжит чуулганы үргэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгон нэмэгдүүлэх;

3.7.Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэхтэй холбоотой аливаа санал хураалт явуулахыг хориглох эрх зүйн үндсийг тогтоох;

3.8.Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох.

д/д	Хуулийн Нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын чуулган	<ul style="list-style-type: none"> • Ээлжит чуулганы үргэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгон нэмэгдүүлсэнтэй холбогдуулан ээлжит чуулганы нээх, хаах хугацааг зохицуулах; • Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын хорооны хуралдаанаар асуудлыг шийдвэрлэх санал хураалтын зарчмыг тодорхойлох; • Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болохтой холбогдох зохицуулалтыг тодотгох; • Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулахтай холбоотой зохицуулалтыг хуульчлах.
2.	-Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын чуулган	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, томилох, огцруулах, чөлөөлөх, түүнд итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх дэгийг боловсронгуй болгох; • Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг томилох тухайгаа Улсын Их Хуралд танилцуулах журмыг тогтоох; • Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх журмыг тогтоох; • Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журмыг тогтоох; • Улсын Их Хурлаар улсын төсвийн төслийг хэлэлцэн батлах дэгийг боловсронгуй болгох; • Хянан шалгах түр хорооны хуралдааны дэгийг нарийвчлан зохицуулах; • Улсын Их Хурлын хуралдааны санал хураалтын зарчим, журмыг тогтоох; • Хууль хэлэлцэх, эцэслэн батлах журмыг тогтоох.

3.	-Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Хууль санаачлах эрхийн хүрээ хязгаартай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах.
4.	-Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилго бүхий ард нийтийн санал асуулга явуулахыг хориглосон зохицуулалт оруулах.

4.Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

4.1.Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах;

4.2.Намын үйл ажиллагаа хууль болон өөрийн дүрэмд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах;

4.3.Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.4.Намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжоор бүрдүүлэх;

4.5.Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Улс төрийн намын тухай хууль -Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль /шинэчилсэн найруулга/	2020 он	<ul style="list-style-type: none"> Намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаа хууль дээдлэх зарчимд суурилсан байх; Улс төрийн намуудын хариуцлагын тогтолцоог тодорхой болгох; Улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх; Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох; Нийт сонгогчдын нэг хувиас доошгүй тооны иргэний дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах журмыг тогтоох.

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 29

Татгалзсан 18

Бүгд 47

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Нарантуяа, Д.Эрдэнэбат, Б.Энх-Амгалан, Ц.Цогзолмаа, М.Оюунчимэг, Х.Нямбаатар нар үг хэлэв.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Хоёр.Хавсралтын 2 дугаар бүлгийн 1, 2, 3 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах. */Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд хийсэн найруулгын засвар/*

“1.Засгийн газрыг эмхлэн байгуулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

1.1.Сонгуулийн дүнгээр аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй тохиолдолд улс төрийн нам, эвсэл заавал олонхыг бүрдүүлж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх шаардлагыг хуульчлах;

1.2.Ерөнхий сайд нь Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, зөвшилцөж чадаагүй тохиолдолд өөрөө өргөн мэдүүлэх зохицуулалтыг хуульчлах;

1.3.Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн дөрвөөс илүүгүй нь Улсын Их Хурлын гишүүн байж болох зохицуулалтыг холбогдох хуульд тусгах;

1.4.Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх зохицуулалтыг хуульчлах.

2.Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллахтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

2.1.Ерөнхий сайд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах зохицуулалтыг хуульчлах;

2.2.Ерөнхий сайдыг огцруулах журам, Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох талаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах;

2.3.Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын чуулган	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын тогтвортой ажиллах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; • Засгийн газар танхимаар ажиллах зарчимд нийцүүлэн Ерөнхий сайд бие даан танхимаа бүрдүүлэх зохицуулалтыг хуульчлах; • Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хуралд оруулах зохицуулалтыг хуульчлах;

			<ul style="list-style-type: none"> Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах хязгаарыг хуульчлах.
--	--	--	--

3.Ерөнхийлөгчид нэр дэвших насны босго, бүрэн эрхийн хугацааг нэмэх талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

3.1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг өндөрсгөж, зөвхөн нэг удаа сонгогдох;

3.2.Ерөнхийлөгчид зөвхөн Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийнх нь хүрээнд тодорхой бүрэн эрх олгож байхаар зохицуулах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	<p>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай;</p> <p>-Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/</p> <p>-холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах</p>	2020 он	<ul style="list-style-type: none"> Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх; Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан хүрээнээс халихгүй байх нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид оруулах; Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрх олгох асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх.

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 23
Татгалзсан 23
Бүгд 46
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 27
Татгалзсан 19
Бүгд 46
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалт дахин явуулъя.

Зөвшөөрсөн 24
Татгалзсан 15
Бүгд 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Гурав.Хавсралтын 3 дугаар бүлгийн 1, 2, 3 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах. /Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд хийсэн найруулгын засвар/

“1.Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

1.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох, гишүүдийг зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллуулах, Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгох журмыг хуулиар тогтоох;

1.2.Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах зохицуулалтыг хуульчлах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Шүүхийн захиргааны тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none">• Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдэд тавих болзол, шалгуур, тэдгээрийг сонгох, томилох, Зөвлөлийн даргыг сонгох журам;• Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг тодорхойлох;• Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах журам.

2.Шүүгчийн хариуцлагыг сайжруулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

2.1.Хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороог байгуулах, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, журмыг хуулиар тогтоох;

2.2.Шүүхийн сахилгын хороо нь хөндлөнгийн нөлөөллөөс ангид байж, төвийг сахиж хараат бусаар шийдвэр гаргаж, шүүгчийг сахилгын шийтгэлийн журмаар албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, сахилгын бусад шийтгэл ногдуулах замаар шүүгчийн ёс зүй, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2.3.Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид, нэр хүндтэй иргэд, хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтдээс нээлттэй нэр дэвшүүлэх замаар холбогдох институцүүдээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах.

д/д	Хуулийн	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах
-----	---------	---------	----------------------------

	Нэр		харилцааны товч утга
1.	-Шүүхийн сахилгын хорооны тухай хууль /анхдагч хууль/, -Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавих болзол, шалгуур, бүрдүүлж байгуулах журмыг тогтоох; • Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх, зөрчлийн шинж байдалдаа тохирсон байх, давхардахгүй байх зарчмыг үндэслэн тодорхойлох; • Хорооны бүрэн эрх, үйл ажиллагааны болон сахилгын зөрчил хянан шийдвэрлэх журмыг хуульчлах; • Хорооны шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг гомдлын дагуу Улсын дээд шүүх эцэслэн хянах журмыг тогтоох.

3.Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

3.1.Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахдаа иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох үндсэн зарчимд нийцүүлнэ.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Шүүх байгуулах тухай болон Шүүхийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт	2021 он	<ul style="list-style-type: none"> • Хүн ам, газар нутаг, шүүгчийн ажлын ачааллыг харгалзан тойргийн шүүх байгуулж болох үндэслэл, журмыг нарийвчлан тогтоох; • Шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, тойргийн зарчмаар шүүх байгуулах нь шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр чөлөөлөх, шилжүүлэх үндэслэл болохгүй байх зохицуулалтыг хуульчлах.

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 24
Татгалзсан 15
Бүгд 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 27
Татгалзсан 14
Бүгд 41
65.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусаав.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ 2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 09-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн 50.7 хувьтай ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль, тогтоомжийг нийцүүлэх түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

4.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

5.Эргүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл.

6.Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

7.Зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

8.Прокурорын байгууллагын 90 жилийн ойн төсөл.

Мөн тэтгэврийн зээлийн үлдэгдлийг тэглэх тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль, тогтоомжийг нийцүүлэх түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

Бямбацогт даргыг индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд уг нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийхээр заасантай холбогдуулан Улсын Их Хурал 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс санал хэлсэн бөгөөд Улсын Их Хурлын даргаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-т заасны дагуу тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ гишүүдээс гарсан санал болон төсөл, түүний хавсралтын үг, найруулгыг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын дэд хэсгийг байгуулан ажиллалаа.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үед тогтоолыг дагаж мөрдөх хугацаа, тогтоолын хавсралтад “төрийн нийтийн өмч”-ийн зохицуулалттай холбоотойгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар нэмэх болон хавсралтаас зарим давхардсан хуулийн төслийг хасахтай холбоотой зарчмын зөрүүтэй 4 санал, тогтоолын төслийн хавсралтын үг, найруулгыг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалтай нийцүүлэх найруулгын шинжтэй 3 бүлэг саналаар санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, түүнтэй холбогдуулан гаргасан саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүн Улсын Бага хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор,

хууль зүйн ухааны доктор Бямбажаргал, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн ухааны доктор Мөнхсайхан, Монгол Улсын гавьяат хуульч Лувсанжав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Янгугийн Содбаатар.

Я.Содбаатар: Энэ ингээд Үндсэн хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хууль, тогтоомжийг нийцүүлэх юмнуудыг хараад үүний дараа холбогдох байгууллагуудад чиглэл өгөгдөөд явчих байх гэж ойлгож байгаа. Би зүгээр энэ тогтоолын төсөл дээр Засгийн газарт нэмэлтүүдийг нь хугацаанд оруулж ирэх чиглэлийн юмыг дараа нь илүүтэй боловсруулж төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан байгаа. Өргөн барих гэсэн байдлаар найруулгын чанартай орох ёстой байсан уу, үгүй юу гэдгийг нэгдүгээрт асууж байна.

Хоёрдугаарт болохоор энэ улс төрийн намын юун дээр бүх юман дээр бол дандаа одоо байгаа хуулиудаа бичээд тэгээд ард талд нь ийм төслийн харилцааны товч утгаар зохицуулалт хийнэ гэсэн юм. Ганцхан улс төрийн намынх дээр бол улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль гэж одоо байхгүй шүү дээ. Тэгэхээр ийм хуулийн нэр бичсэн байх юм. Тэгэхээр энэ бол цаашдаа гарах байх л даа. Энэ хэлэлцүүлгийн үед хамгийн их яригдсан улс төрийн намуудын энэ намын хөрөнгийн эх үүсвэр зарцуулалт нийтэд ил тод байх, санхүүжилтийн асуудал гээд их олон юмнууд явж байгаа. Ер нь бол яах вэ энэ бол яг хууль бол одоо хүчин төгөлдөр хууль байхгүй шүү дээ.

Тийм учраас Улс төрийн намын санхүүжилтийн хууль гэдгээ тэр 4.4 дээрээс авах нь зүйтэй юм болов уу. Яагаад гэхээр бусад хуулийнх жишгийг харахад бол одоо байгаа хуулиудаа урд бичээд тэгээд байхгүй хуулиудаа бол ард талд нь гаргах юмнуудаа бол ийм агуулгаар явж байгаа учраас энд бол одоо байхгүй хуулийн нэр бичсэн. Шууд нэршлийг нь явж байгаа учраас энийг анхаараач гэж.

Хоёрдугаарт тогтоолын ерөнхий юун дээрээ бол ингээд бичсэн байгаа юм л даа. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах гээд үүний найруулга дээр ийм хоёр санал байсан. Үндсэн хууль 5 сарын 25-наас хэрэгжиж эхэлнэ. Тэгээд энэ удаагийн Үндсэн хуулийн асуудлууд бас олон жил яригдсан. 30 жил яригдсан. Сүүлийн гурван парламент дамжиж яригдсан олон асуудлуудыг бид нар шийдсэн шүү дээ. Энэ чиглэлийн ажиллагааг сурталчлах ажлыг тэр 3-аараа өгч байгаа юм байна. Тийм учраас парламентын ардчиллыг төлөвшүүлэх ялангуяа байгалийн баялгийг ард иргэдэд хүргэх чиглэлээр засаглалын тэнцвэржилтийг хангах шүүх засаглалтай холбоотой орон нутгийн юутай холбоотой гээд маш олон асуудлуудыг олон жил ярьсан асуудлуудыг олон түмэн сурталчлах чиглэлийн ажлаа нэлээд эрчимжүүлэх төсөв мөнгө гаргах чиглэл рүү Засгийн газрын түвшинд бас нэлээд ажиллах шаардлага байна гэдэг асуудлыг бас тодотгож хэлье.

Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэлчихсэн үү, асуулт уу. Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Тогтоол маань үндсэндээ бас хоёр агуулгатай заалт орсон байгаа. Нэгдүгээрт нь бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хууль, тогтоомжийг нийцүүлэх түүнтэй холбогдуулан нийцүүлэх ажлыг хийж хэрэгжүүлэх юм. Үүнтэй холбоотойгоор бид нар 45 хууль Монгол Улсын Их Хурал батална. 45 хуулийн 2 хууль нь бол анхдагч хууль. Үндэсний баялгийн сангийн тухай хууль. Шүүхийн сахилгын хорооны тухай хууль. 23 хуульд бид нар нэмэлт, өөрчлөлт оруулна, 20 хуульд шинэчилсэн найруулга хийнэ. Энэ ажлыг бол зохион байгуулж хуулийн төслийг өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгож байгаа. Энэ ажлыг бол 2020 оны хавар зарим хуулийг батлах ёстой. Тухайлах юм бол Улсын Их Хурлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль гэх мэтийн хуулиудыг бол зайлшгүй энэ Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд батлах ёстой. Бусдыг нь бол 2020 ондоо багтаагаад батлах ийм график гаргаж хавсралтаар бас хугацаатай үүргийг гаргаж Засгийн газарт өгч байгаа.

Хоёрдугаарт нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол сурталчлах ажлыг Засгийн газар зохион байгуулах ёстой. Нэлээд олон жил ярьсан Үндсэн хууль, нэмэлт, өөрчлөлт үнэхээр юу нь яаж өөрчлөгдөх вэ гэдгийг олон нийтэд ард иргэдэд хүргэх сурталчлах ажлыг Улсын Их Хурал Засгийн газар Улсын Их Хурлын нийт гишүүдэд бас тодорхой энэ тогтоолоор үүрэг болгож өгч байгаа.

Дараагийн асуулт. Улс төрийн намтай холбоотой зохицуулалтыг бид нар Үндсэн хуульд оруулж өгсөн. Урд нь бол Үндсэн хуульд тийм зохицуулалт байгаагүй. Үндсэн хуульдаа Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамаарсан байх гэсэн асуудлыг Үндсэн хуульд тусгаж өгсөн. Үүнтэй холбоотойгоор Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлага гарч байгаа. Мөн бас намын үйл ажиллагаа санхүүжилт нь ил тод байх зарчмыг Үндсэн хуульдаа суулгаж өгсөн. Үүнтэй холбоотойгоор бас Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийг зайлшгүй батлах шаардлагатай гэж үзэж байгаа.

Ер нь бол Улс төрийн намуудыг бас санхүүжилт нь ил тод бус байна. Янз янзын байдлаар авлигал албан тушаалын асуудал яригддаг гэх мэтийн шүүмжлэлүүд их байдаг. Тийм болохоор энэ санхүүжилтийг нь ил тод болгож байж намаар дамжсан асуудал, улс төртэй холбоотой улс төрийн авлигын асуудал байгаа. Тэрийг цэгцлэх шаардлага байгаа учраас санхүүжилтийн тухай хууль гэсэн бие даасан хууль батлах ёстой гэж ажлын хэсэгтэй бас ярилцаж ингэж оруулж ирсэн байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүддээ мэндчилгээ дэвшүүлье.

1 дүгээр сарын 6-нд Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд төржээ, 1 дүгээр сарын 7-нд Улсын Их Хурлын гишүүн Дамдины Хаянхярваа төржээ. 1 дүгээр сарын 7-нд бас Улсын Их Хурлын гишүүн Долгорсүрэнгийн Сумъяабазар төржээ. Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс Нямаагийн Энхболд Дамдины Хаянхярваа Долгорсүрэнгийн Сумъяабазар нарын гишүүддээ төрсөн өдрийн мэнд хүргэж эрүүл, энх аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөе.

Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх тухай асуудал дээр нэг яаралтай тодорхой шийдэх эрх зүйн орчныг нь бүрдүүлэх хэдэн асуудал үүсээд байх шиг байгаа юм.

Нэг дэх нь болохоор сая үүссэн нөхцөл байдал байгаа. Тэтгэврийн зээлийн өрийг тэглэх тухай асуудал. Энэ асуудал бол ингээд чуулганаар хэлэлцэгдээд батлагдаад цаашаа явах юм шиг байна. Үүнээс үүдэн гарч байгаатай холбогдуулаад цаашид эдийн засгийнхаа нөхцөл байдлыг дордуулахгүй байх, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ нэг тэгш бус байдал үүсээд байна гэсэн талцлыг нэг тийш нь болгоход хэд хэдэн эрх зүйн орчныг зайлшгүй бид нар ингэж цэгцлэх шаардлагатай байгаа юм. Тэгээд энэ дээр нэг ийм нийт иргэдийнхээ өрийн дарамтыг бууруулах тэгш бус байдлыг арилгахад энэ баялгийн хуваарилалтаа зөв хийх оновчтой болгох хэд хэдэн хуулийн үндсэн эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэх шаардлага бол байгаа гэж харж байгаа. Энэ дээр жишээлбэл төрийн нийтийн өмчит энэ компанийг аж ахуйн нэгж иргэдэд эзэмшүүлэх тухай хуулийн төслийн тухай үзэл санаа энэ дээр огт тусгагдаагүй байгаа. Энэ яаж цаашид шийдэгдэх ёстой юм бэ гэдэг дээр би нэг хариулт авмаар байна.

Хоёрдугаарт бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндэсний баялгийн сангаа буй болгоно гэж тодорхойлсон. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Ирээдүйн өв сангийн тухай хуулийг хүчингүй болгоод хэзээнээс эхэлж явах ёстой юм бэ. Энэ дээр яг төлөвлөгөөн дээр яаж тусгагдсан юм. Энэ дээр цаг хугацаа алдах бол эрх байхгүй гэж ингэж ойлгож байгаа. Тэгж байж энэ баялгийн сангаар дамжуулж энэ тэгш бус байдлаа арилгах энэ стратегийн ордтой холбоотой энэ үндэсний компанийг байгуулсны дараа бид нар энэ орлогыг иргэддээ тэгш шударга хуваарилах нөхцөл байдал үүснэ. Энийг хэзээ яаж тодорхойлох юм бэ гэдэг дээр надад нэг тодорхой хариулт хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь энэ Хотын эрх зүйн байдлын тухай хуультай холбоотой асуудлаар энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дараа юу яаж өөрчлөгдөх юм. Хэзээнээс эхэлж хэрэгжих юм бэ. Одоо орон нутгийн сонгуулийн тухай хууль яригдаж байгаа. Орон нутгийн сонгуулийн тухай хууль бол аймаг, сум дүүргийн хэмжээнд ингэж зохицуулагдана гэж томъёологдсон. Тэгэхээр бид нар энэ дээр орон нутгийн сонгуулийн тухай хуульд энийгээ энэ орон нутгийн Сонгуулийн хуульд тодорхой хэлж өгөх хэрэгтэй. Энэ Сонгуулийн хууль 10 дугаар сард хэрэгжихдээ хотын эрх зүйн статусыг бол авч үзэж бол амжихгүй ээ. Хотын эрх зүйг бол эрх зүйн орчноо шинэчилж байж хот чинь өөрөө тусдаа статус болох юм чинь Сонгуулийн хуулийн зохицуулалт бол энд заавал тусгах ёстой.

Өнөөдөр тусгаагүй. Энэ бол цаашдаа хэрэгжих үү, үгүй юу гэдгийг тодорхой болгох хэрэгтэй. Энэ өнөөдөр хүртэл тодорхойгүй явж байгаа. Орон нутгийн сонгуулийн хууль дээр бид нар энийг ямар байдлаар тусгах юм. Тусгах юм уу, тусгахгүй юм уу. Тусгахгүй бол орон нутгийн хууль бол одоо яг хуучин нутаг дэвсгэрийнхээ хуулиар мөрдөгдөнө. Тусна гэвэл бид нар эцсийн хугацаанд амжуулж энэ Хотын эрх зүйн байдлын хуулиа батална гэдэг ийм ойлгомжтой байдлыг үүсгэх зайлшгүй шаардлагатай байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар хариулт, ямар санаа оноо юун дээр хийгдэж байгаа юм бэ гэдэг нь надад тодорхой хариулт хэрэгтэй байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 6.2 дахь заалт маань Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий түүний баялаг, ой, усны нөөц төрийн өмч мөн гэсэн заалт байсан. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нэлээд дэлгэрүүлж байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэн хүртэх бололцоо боломжийг бий болгох тодорхой заалтууд орсон. Энэ дээр бол Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар байгалийн баялаг, ой, ус, ан амьтан бол төрийн нийтийн өмч мөн гэсэн зохицуулалт орсон. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүйн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэсэн гэх мэтийн нэлээд хэдэн тодорхой заалтууд орсон. Үүнтэй холбоотойгоор дагаж гарах хуулиуд дээр бид нар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулъя гэж ирж байгаа.

Үндэсний баялгийн сан байгуулах тухай шинээр. Анхдагч бол Үндсэн хуульд заасан зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сандаа байгалийн баялгийнхаа үр өгөөжийг хуримтлуулдаг байя. Өсгөдөг байя. Үүнээсээ одоо болон ирээдүй хойч үдээ тэгш хүртээмжтэйгээр хүртээх асуудлыг зохицуулж оруулж өгье гэсэн заалттай холбоотойгоор үндэсний баялгийн сангийн тухай хуулийг бас батлахаар орж ирж байгаа. Мөн төрийн нийтийн өмч болсонтой холбоотойгоор төрийн болон нийтийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм асуудлыг бас тусгаж өгсөн байгаа. Энэ дээр бас манай ажлын хэсэг Лувсанжав гуай бас нэмээд хариулж болно.

Хоёр дахь асуудал. Орон нутгийн бүлэгтэй холбоотой бас тодорхой заалтууд орсон. Үндсэн хуульд бол орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх төвлөрлийг сааруулах чиглэлээр тодорхой өөрчлөлтүүд орсон. Мөн Дархан, Эрдэнэт 21 аймгийн төвийг улсын болон орон нутгийн чанартай хот тосгон байгуулах асуудлыг тодорхой болголцож өгсөн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хуульдаа бид нар энэ оны хавартаа багтаад 2020 оны 5 сардаа багтаагаад энэ Дархан, Эрдэнэт хотын статусыг сэргээх асуудлыг оруулж ир гэсэн чиглэлийг бас Засгийн газар өгсөн байгаа. Мөн одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийг ойрын үед Улсын Их Хурал бас хэлэлцэх ёстой. Хэлэлцэхээр төлөвлөж ажиллаж байгаа.

Мөн одоо Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Нутгийн удирдлагын тухай хууль гэсэн хуулиудыг Улсын Их Хурлаар хэлэлцэхээр төлөвлөж байгаа. Ийм хуулиудыг хэлэлцээд явах юм бол таны ярьж байгаа энэ Дархан, Эрдэнэт хот болон 21 аймгийг хот болгох асуудал бол харьцангуй хурдтай анхаарч шийдэх ёстой гэж үзэж байгаа иймэрхүү байдлаар төлөвлөж байгаа.

Одоо харин Сонгуулийн хуультай яаж уялдуулах вэ гэдгийг бодох ёстой болно Энэ дээр.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Нэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хураалт явуулъя.

1.Тогтоолын төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.Энэ тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт. Санал хураалтад 45 гишүүн оролцож, 31 гишүүн дэмжиж, 68.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралт /цаашид хавсралт гэх/-ын 1 дүгээр бүлгийн 1 дэх хэсгийн хүснэгтэд доор дурдсан агуулга бүхий мөр нэмэх:

2.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	• Төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгох
----	--	---------	---

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт. Санал хураалтад 44 гишүүн оролцож, 30 гишүүн дэмжиж, 68.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Хавсралтын 1 дүгээр бүлгийн 1 дэх хэсгийн хүснэгтээс 2 дахь мөр, 3 дахь хэсгийн хүснэгтийн 5, 6 дахь мөр, 4 дүгээр бүлгийн хүснэгтээс 2 дахь мөрийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт. 65.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Хавсралтын 1 дүгээр бүлгийн 1 дэх хэсгийн хүснэгтийн 4 дэх мөрийн “Хуулийн төслийн зохиуулах харилцааны товч утга” гэсэн баганын “Цөмийн энергийн тухай хуулийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж нэмж Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх;” гэснийг “Хуулийн зохицуулалтыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх;” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт. 65.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн найруулгын санал

Нэг. Хавсралтын 1 дүгээр бүлгийн 1, 2, 3, 4 дэх хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах. /Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд хийсэн найруулгын засвар/

“1.Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

1.1.Байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж (татвар, хураамж, ашиг г.м) –ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь Монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах. Үр өгөөж гэсний ард (татвар, хураамж, ашиг гэх мэт) гэж байгаа юм билээ шүү.

1.2.Үндэсний баялгийн санг байгуулахдаа энэхүү сан нь хөгжлийн болон хуримтлалын сан байх, түүний хувьцаа эзэмшигчийн хувьд хөрөнгийг нь захиран зарцуулах чиг үүргийг Засгийн газар хэрэгжүүлэх, санд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны төлбөр, төрийн өмчийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого, газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүн хуваах гэрээний орлого, төрийн хувьцааны ногдол ашиг, сангийн хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх;

1.3.Сангийн хөрөнгийн удирдлагын компани сангийн хөрөнгийг удирдахдаа хараат бус, бие даан ажиллах, компанийн болон сангийн удирдлагын сайн засаглалыг хэвшүүлэх, сангийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх, түүний үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэддээ хүртээхдээ тэгш байдал, шударга ёсны зарчмыг дээдлэх, сангийн хөрөнгийн удирдлагын компанийн давуу эрхийн хувьцааны ногдол ашиг олгох;

1.4.Газрын хэвлийн баялаг ашигласны улмаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг хангах, байгалийн тэнцлийг хадгалах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох; • Стратегийн ач холбогдолтой ордын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох; • Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох; • Онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, саналыг нь авч, тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах; • Ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хадгалах, нөхөн сэргээх уг үйл ажиллагаанд оролцогчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгох.
2.	- Байгаль орчны тухай, Байгаль орчинд нөлөөлөх	2020 он	<ul style="list-style-type: none"> • Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд

	байдлын үнэлгээний тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбоотой зохицуулалтыг нэмэх.
3.	-Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Гадаадын улс орны цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох зохицуулалтыг тусгах.
4.	-Үндэсний баялгийн сангийн тухай хууль /анхдагч хууль/ -Засгийн газрын тусгай сангийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Газрын хэвлийн баялаг ашигласны орлогоос Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, түүнийг санхүүгийн үр ашиг бүхий төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, үнэт цаас гаргах зэргээр арвижуулах; Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, шударгаар хуваарилах зарчмыг баримтлах; Засгийн газрын тусгай сангийн зохицуулалтуудыг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нийцүүлэх.
5.	-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг баталгаажуулах; Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг зөрчиж байгаа эсэхэд иргэдийн зүгээс хөндлөнгийн хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоох.
6.	-Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох.

2.Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төсөв, санхүүтэй холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

2.1.Улсын Их Хурал цаг хугацааны шалгуурыг даах Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогыг батлахдаа нийгмийн зөвшилцлийг хангаж байх;

2.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог үндэсний түвшинд бүрдүүлэх, Засгийн газрын бүтцийн үндсэн нэгжийг байгуулах эрх зүйн үндсийг тогтоох;

2.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахдаа Хөгжлийн болон Үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх эрх зүйн үндсийг тогтоох;

2.4. Улсын Их Хурал жил бүрийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, харин төсвийн орлого, зарлагын бүтцийг хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчилж болохоор зохицуулах;

2.5. Төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;

2.6. Төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -Холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	2020 он	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах, төлөвлөлтийн байнгын, мэргэшсэн тогтолцоо бүрдүүлэх, бодлого төлөвлөлт нь дээрээсээ доош, доороосоо дээш чиглэх зарчмыг тодорхойлж, цаг хугацааны болон нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалсан орон зайн төлөвлөлт хийх механизмыг бүрдүүлэх; • Бодлого, төлөвлөлт нь судалгаанд үндэслэсэн байх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтвортой тогтолцоо бий болгох; • Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Засгийн газрын үндсэн бүтцийн нэгж бий болгох, уг нэгж нь улс төрийн сонгуулийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой ажиллах зохицуулалтыг бий болгох; • Бодлого боловсруулах, төлөвлөлт хийх хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх онцлог тогтолцоог бүрдүүлэх.
2.	-Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Улсын Их Хурал нь Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зардал болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн улсын төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болох зохицуулалтыг тусгах; • Жил бүрийн төсөв нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд суурилсан байх шаардлагыг хуульчлах; • Улсын Их Хурлаас төсвийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох.
3.	-Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Сонгуульд өрсөлдөх улс төрийн намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх шаардлагыг тусгах; • Энэхүү шаардлага хангагдаагүйгээс үүсэх хууль зүйн үр дагаврыг хуульчлах.

4.	-Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 он	<ul style="list-style-type: none"> • Төрийн аудитын байгууллагын бие даасан, үйл ажиллагааны хараат бус байдлыг сайжруулах, эрх хэмжээг нэмэгдүүлэх; • Зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх.
----	--	---------	--

3.Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгож, хариуцлагыг сайжруулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

3.1.Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахдаа Үндсэн хууль зөрчсөнийг нь Үндсэн хуулийн цэц тогтоосон байхыг үндэслэл болгох;

3.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох зохицуулалтыг боловсронгуй болгох;

3.3.Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар эцэслэн батлах, Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр өгдөг үндсэн зарчмыг хадгалж, харин Үндсэн хууль болон бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол нууц санал хураалт явуулж байхаар өөрчлөх;

3.4.Хянан шалгах түр хороог хуулиар тусгайлан тогтоосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг арга хэрэгсэл ашиглан Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан эсэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор байгуулах, түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчлах;

3.5.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хууль санаачлах хүрээ, хязгаарыг хуулиар тогтоох;

3.6.Улсын Их Хурлын хууль тогтоомжийн төсөл хэлэлцэн батлах үйл ажиллагааны болон батлагдан гарч буй хууль тогтоомжийн чанарыг сайжруулах, түүнчлэн хянан шалгах бүрэн эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын ээлжит чуулганы үргэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгон нэмэгдүүлэх;

3.7.Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэхтэй холбоотой аливаа санал хураалт явуулахыг хориглох эрх зүйн үндсийг тогтоох;

3.8.Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох.

д/д	Хуулийн Нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
-----	-------------	---------	---

1.	-Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын чуулган	<ul style="list-style-type: none"> • Ээлжит чуулганы үргэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгон нэмэгдүүлсэнтэй холбогдуулан ээлжит чуулганы нээх, хаах хугацааг зохицуулах; • Улсын Их Хурлын Байнгын хороо, нэгдсэн чуулганы хуралдаанаар асуудлыг шийдвэрлэх санал хураалтын зарчмыг тодорхойлох; • Улсын Их Хурлын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болохтой холбогдох зохицуулалтыг тодотгох; • Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулахтай холбоотой зохицуулалтыг хуульчлах;
2.	-Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын чуулган	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, томилох, огцруулах, чөлөөлөх, түүнд итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх дэгийг боловсронгуй болгох; • Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг томилох тухайгаа Улсын Их Хуралд танилцуулах журмыг тогтоох; • Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх журмыг тогтоох; • Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журмыг тогтоох; • Улсын Их Хурлаар улсын төсвийн төслийг хэлэлцэн батлах дэгийг боловсронгуй болгох; • Хянан шалгах түр хорооны хуралдааны дэгийг нарийвчлан зохицуулах; • Улсын Их Хурлын хуралдааны санал хураалтын зарчим, журмыг тогтоох; • Хууль хэлэлцэх, эцэслэн батлах журмыг тогтоох.
3.	-Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Хууль санаачлах эрхийн хүрээ хязгаартай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах.
4.	-Ард нийтийн санал асуулгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилго бүхий ард нийтийн санал асуулга явуулахыг хориглосон зохицуулалт оруулах

4.Улс төрийн намтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

4.1.Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах;

4.2.Намын үйл ажиллагаа хууль болон өөрийн дүрэмд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах, хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүддээ нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах;

4.3.Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.4.Намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжоор бүрдүүлэх;

4.5.Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Улс төрийн намын тухай хууль -Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль /шинэчилсэн найруулга/	2020 он	<ul style="list-style-type: none"> • Намын чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаа хууль дээдлэх зарчимд суурилсан байх; • Улс төрийн намуудын хариуцлагын тогтолцоог тодорхой болгох; • Улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх; • Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох; • Нийт сонгогчдын нэг хувиас доошгүй тооны иргэний дэмжлэг авсны үндсэн дээр улс төрийн нам байгуулах журмыг тогтоох.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Асуулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Нарантуяа гишүүн. Энх-Амгалан гишүүн, Эрдэнэбат гишүүн орсон л байна.

3.Нарантуяа: Энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл гарах гэж байгаа юм байна. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг санхүүжүүлэхтэй холбоотой. Энд аягүй сонин юм ажиглагдаад байна л даа. Улсын Их Хурал ямар хуулийн төсөл батлах үзэл баримтлалыг ингээд шууд хүрээг нь зааж өгөх гээд байгаа байхгүй юу. Амьдрал баян энэ хууль бол доороосоо батлагдах ёстой шүү дээ. Ерөнхий хүрээ жагсаалтаа л баталж өгнө үү гэхээс энэ хуулийг оруулж ирэхдээ ийм юмыг оруул, ийм юмыг боль, ийм юмыг тусга гэж ингэж нарийвчилж заах юм уу. Энэ зааснаас чинь өөр юм амьдралын явцад энэ хуулиудыг боловсруулж байхад ороод ирвэл яах юм бэ? Их Хурлын тогтоолд тусгагдаагүй асуудал учраас энийг энэ хуулийн төсөлд оруулахгүй гэх юм уу. Энэ сүүлийн энэ саяын уншсан юман дээр чинь учир дутагдалтай байна. Энийг бол дахиж яримаар байна. Үндсэн хуулийнхаа яг өөрчлөлтийн хүрээнд зайлшгүй гаргах зохицуулах шаардлагатай байгаа тэр харилцаа хууль хоёрынхоо нэрийг л хэлнэ үү гэхээс биш дотор нь юу оруулахыг ямар байдлаар тусгахыг ингэж нарийвчлахгүй байх.

Их Хурал эсвэл зүгээр захиалгаар хуулийн төслийг ийм юм бичээд ир гэж Засгийн газарт өгөх гэж байгаа юм уу хаашаа юм.

Г.Занданшатар: Асуулт байхгүй. Чуулгандаа оролцож, хэлэлцүүлэгтээ идэвхтэй оролцож бай. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг зааж байна шүү дээ. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гажуудуулсан хуульбаталж болохгүй гэж зааж байгаа.

Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Хурлын дарга аа гишүүдийн үгийг бүтэн хэлүүлчих л дээ. Ганцхан таны удирдлагаар энэ хурал явах биш та хурал зохион байгуулж байгаа. Болохгүй байхгүй юу наадах чинь. Зөв шүү дээ. Ойлгохгүй ч ярьдаг биз дээ. Зарим нь бүр тэс хөндлөн ярьдаг биз дээ. Бямбацогтоо яагаад байгаа юм бэ. Энэ гишүүдийн хэлэх үгийг битгий хязгаарлаад бай л даа.

Г.Занданшатар: Үндсэн хууль зөрчиж болохгүй ээ. Энэ байгалийн баялаг зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлт гээд орж ирж байна л даа.

Д.Эрдэнэбат: Энэ дээр юу байх вэ. Найруулга дээр нь ч байна, суурь тогтоолын төслийн хавсралт дээр ч байна. Энэ үндэсний баялгийн санг байгуулахдаа яах вэ гэдгийг зааж өгөөд хөрөнгийг нь захиран зарцуулах чиг үүргийг Засгийн газар хэрэгжүүлэх гэж нэг юм орсон байх юм. Үндэсний баялгийн сан тэгээд дараагийн хэсэг дээр болохоор Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг удирдахдаа хараат бус бие даан ажиллана гээд заасан байх юм.

Хараат бус бие даан ажиллаж байгаа санд яахаараа Засгийн газар чиг үүрэг өгч байх ёстой юм бэ. Наадах чинь ингээд нэг зөрчилтэй юм орж ирээд байна шүү дээ. Та нар тэр Ирээдүйн өв сангийн тухай хууль дээр бол ирээдүйн өв сангийн удирдлага бол өв сан нь өөрөө хараат бус бие даан ажиллана гэдгийг байхгүй болгоод Засгийн газар хариуцахаар оруулаад ирсэн шүү дээ. Өөрчилсөн хуулийг. Одоо бүр энийгээ ингэж баталгаажуулж байгаа юм бол ямар хэрэг байсан юм бэ. Тэгээд энэ ирээдүйн өв сан чинь ард түмний сан. Хараат бус үйл ажиллагаа явуулах ёстой. Бие даан ажиллах ёстой. Корпорацын хэмжээнд байх ёстой гэххээд дээрээс нь Засгийн газар чиг үүрэг өгдөг гэдэг чинь наадах чинь авцалдахгүй байна шүү дээ. Энийгээ өөрчлөхгүй юм уу. Наадах чинь маш буруу томъёолол шүү. Би бол энийг дэмжихгүй.

Хурлын дарга аа дахиад нэг хэлье. Гишүүдийг үг хэлэх боломжоор нь хангаж өг. Гишүүд ойлгож ч хэлж болно, ойлгохгүй ч хэлж болно. Энэ гишүүний эрхийн асуудал шүү дээ хуулиар тогтоосон.

Г.Занданшатар: Дэгээ сахих ёстой. Дэгийн хүрээнд, хэлэлцэж байгаа асуудлаар ярих ёстой.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийн урилгаар Ховд аймгийн Цаст Алтай сургуулийн багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш нартаа эрдэм номын эх ажилд нь Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс амжилт хүсье. Сайн сайхныг ерөөе. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд хийсэн найруулгын өөрчлөлтийн төслийг бол дэмжиж байна. Тэгээд энэ хуулийн зохицуулалтыг хийхдээ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг нийцүүлэх тэр хуулийн зохицуулалтыг хийхдээ Монгол Улсын иргэдэд өмчлүүлэхээс бусад газар түүнчлэн газрын хэвлий түүний баялаг ой, усны сан, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгох гэдэг асуудал дээр нэлээд анхааралтай хандаж энийг их тодорхой болгоорой гэж ажлын хэсгийнхэндээ хүсэж байгаа юм. Энэ бол нэгдүгээрт Үндэсний аюулгүй байдлын бодлого газар болон түүний хэвлий дэх байгалийн баялаг зөвхөн ард түмний мэдэлд төрийн өмчид байна гэсэн суурь зарчмаа их сайн анхаарч энийгээ боловсруулаарай гэж хэлэх гээд байгаа юм. Үндсэн хууль хэлэлцэж байхад бол төрийн болон нийтийн гэдгийг бол төрийн болон ард түмний гэдэг ойлголт шүү гэдэг ийм тайлбар явж байсан учраас би энийг ярьж байгаа юм.

Тэгээд дээр нь энэ асуудлууд явахаар энэ зүйл маань цаашдаа явж байгаад хоёрдугаарт нөгөө патент лиценз нөгөө өмч хувьчлалын тасалбар, гэрчилгээ энэ газар эзэмшүүлэх гэрчилгээ болон гэрээтэй холбогдоод хэдэн хүмүүс төрийн бус байгууллага байгуулаад энэ манай нийтийн өмч гэдэг байдлаар авч тэрийгээ ингэж өөрийн болгох асуудал байж таарахгүй шүү. Тэгэхгүй бол энэ чинь яг өмнөх шигээ явчих вий гэдэг зарчим барьж байгаа учраас нэгэнт ард түмний мэдэлд тэгээд одоо энэ баялгийн сан бий болгоод тэрийгээ ард түмэндээ зориулж хуваарилах гэж байгаа бол органик хууль дээрээ хуулийнхаа зохицуулалтыг хийхдээ энэ зарчмуудыг онцгой анхаарч тэрийгээ бүр маш тодорхой болгож тайлбарлахгүй бол хуулийн зөрүү гараад тэгээд сүүлдээ энэ маань нийтийн өмч гэдэг бол паблик юм.

Тийм учраас бид нар нэгдэж байгаад энийг авч болно. Энэ сумын тэдэн хүмүүс нэгдсэн. Ийм ийм хүмүүс гарын үсэг зурсан. Тийм учраас минийх гэдэг ийм зарчмаар хандаж болохгүй шүү гэдэг ийм нөхцөл байдлыг би хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэдэнбалын Цогзолмаа гишүүн үг хэлнэ. Дэмжсэн дэмжээгүй гурван гишүүн л үг хэлнэ.

Ц.Цогзолмаа: Үндсэн хуулийн өөрчлөлтөд хэлэлцэж байгаа асуудлын найруулгын санал дээр 1.1 дээр үндсэн зарчим болгож баримтлах ёстой байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулаад боловсруулах хуулийн төсөлд дор дурдсан чиглэл баримтална гээд ингээд явж байгаа.

1.1дээр тэр тэгш хүртээмжтэй шударга байх зарчим гэдэг энэ үгээ яг найруулгаар нь оруулж өгөх нь зөв байх гэсэн тодорхой саналыг хэлмээр байна.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн. Мөнхөөгийн Оюунчимэг.

М.Оюунчимэг: Би дэмжиж үг хэлж байна. Энэ бол маш чухал заалт бид бол цаг алдалгүй энийгээ батлах ёстой гэсэн байр суурьтай байна. Энэ дээр нэг санал байгаа юм. Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгоно гэж тодорхой заасан байгаа. Энэ дээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо 2016 оны 11 сарын 23-ны өдөр энэ экологийн цагдаа бий болгох асуудлаар Засгийн газарт тогтоолоор үүрэг өгч байсан. Улсын Их Хурлын даргаас бидэнтэй хамт яг тэр газар

дээр нь түгээмэл тархацтай ашигт малтмалын газрууд Туул голын эрэг орчимд хүртэл ажиллаад энэ маань сая Засгийн газрын хуралдаанаар ороод ажил хэрэг болсонд би үнэхээр их талархалтай байгаа. Энэ дээр гэхдээ бас нэг асуудал байгаа юм. Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагыг бэхжүүлэх ялангуяа энэ шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн байгаль орчинд учруулан хохирлын үнэлгээг тогтоох тийм нэгж бий болгохгүйгээр энэ маань өөрөө хэчнээн экологийн цагдаа бий боллоо ч гэсэн нөгөө нэг ажиллах бүтэц нь санхүүжилтийн асуудлуудыг нь тодорхой шийдэхгүй болохоор очоод хана мөргөдөг.

Шүүх дээр очоод бүхэл бүтэн байгаль орчинд хохирол учруулаад гол мөрний усны эсрэг том ноцтой гэмт хэрэг үйлдсэн байгаад байхад шүүх дээр очоод нөгөө мөнгө төлсөн компани ч юм уу эсвэл хувь хүн дээр нь талд нь гардаг энэ зүйл өнөөдөр түгээмэл байгаад байгаа учраас энэ асуудлыг бид хэлэлцэхдээ бас зохицуулах хуулиудад яг саяын энэ заалтад тодорхой тусгаж өгөх саналыг би бас хэлмээр байгаа юм. Яагаад гэвэл өөрөө энэ маш чухал зүйл байгаа юм. Ялангуяа энэ түгээмэл тархацтай ашигт малтмал байна. Гол мөрний эрэг орчим тэр байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр зөвшөөрөл авсан хирнээ орон сууцны байшин барилгууд барьдаг энэ нь өөрөө гол мөрөн татрах маш ноцтой аюул жишээлбэл нийслэл Улаанбаатар хотод үүсээд би Туул голын цагдаа би болгоё. Энэ нь өөрөө сая экологийн цагдаа гэдгээр Засгийн газар маань шийдээд ингээд явж байна л даа.

Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолыг Засгийн газар маань биелүүлж байгаа нь сайн хэрэг. Харин энэ маань нөгөө доод шатандаа очоод хэрэгжих тэр зохион байгуулалтыг нь маш сайн хийж өгөхгүй бол хэрэгжих дээр тулаад байгаа юм. Тэгэхээр бид нар Их Хурал хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах энийг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор парламентын ардчиллыг төлөвшүүлэх ард түмний засаглах эрхийг нэмэгдүүлэх хүрээнд энэ асуудлуудыг тодорхой тусгаж өгөх дээр илүү их анхаарах хэрэгтэй байна гэдэг дээр би саналаа хэлж байна.

Хоёр дахь нь түрүүн Энх-Амгалан гишүүний хэлдэг тэр төрийн нийтийн өмч байна гэдэг дээр маш тодорхой зааж өгөхгүй бол энийг хуулийг гуйвуулж ашиглах зүйлүүд нөгөө доод шатандаа нэгж дээр гараад байдаг учраас Улсын Их Хурал маань нэгэнт ийм том Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж түүхэн ийм үүргээ гүйцэтгэж байгаа учраас амьдралдаа хэрэгжих тодорхой заалтууд дээр анхаарч ажиллах нь зөв болов уу гэсэн байр сууриа илэрхийлмээр байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар гишүүн. Дэмжсэн гурав хэлээд дууссан.

Х.Нямбаатар: Тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгвэл би хэлж болохгүй юм байна шүү дээ.

Г.Занданшатар: Та үгээ хэлчих. Би Оюундарь гишүүнд хэлсэн юм.

Х.Нямбаатар: Тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Нэг зүйлийг чуулганы хуралдаан бүр дээр хэлээд байгаа. Энэ юу вэ гэвэл тэр захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ нэлээд тийм он удаан хугацаанд хийгдэх ийм өөрчлөлт байгаа. Улсын болон орон нутгийн шинж чанартай хот байгуулах тэдгээрт Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг

хуулиар шилжүүлэх ийм процесс. Зүгээр бид бол хэдхэн сарын өмнө баталсан Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалыг одоо зарим нь мартаж эхлээд байна. Зөвхөн Дархан, Эрдэнэтийг л хот болгоод энэ өөрчлөлт ингээд болчих агуулгатай яригдаад байгаа. Сум суурин газрын бүх төвүүд хүн ам олноор суурьшиж байгаа бүх газруудыг цаашид хот тосгон болгож өөрчлөх орон нутгийн төсвийн хуваарь өөрчлөгдөх хөрөнгө оруулалтын хуваарилалт өөрчлөгдөх энэ зүйл дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бүр онцгой анхаарч ажилламаар байгаа юм. Ер нь зүгээр ний нуугүй хэлэхэд энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр энэ хуульчдын судлаачдын маш том баг ажиллаж байж энэ бүх хуулийн төслүүдийн боловсруулалт хийгдэхгүй бол хам хум сонгуулийн өмнө 2-ийг нь батална. Сонгуулийн дараа үлдсэн дөчин хэдийг батална гэдэг ийм агуулгатай асуудалд хандаж болохгүй байх.

Өөрөөр хэлбэл эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд бүгд хоорондоо харилцан уялдаатай шүтэлцээтэй ийм өөрчлөлтүүд органик хуулиуд гарч ирнэ. Эдгээр хуулиудыг боловсруулахын тулд маш том баг системтэй ажиллаж өөр хооронд нь уялдаа бүхий ийм хуулийн төслүүдийн боловсруулалтыг хийж ажиллаасай л гэж бодож байна. Яг одоогоор бол Хэрэг эрхлэх газрын дэд дарга сууж байх шиг байна. Энэ хэрэг эрхлэх газар дээр яг энэ чиглэлээр тийм том төлөвлөгөө энэ тэр гарсан юм байгаа бол тэрэнтэй чинь бас бид нар гишүүдэд нэг танилцуулмаар байгаа байхгүй юу. Гишүүдээс нэг санал энэ тэр авах ийм ажлуудаа уялдуулж л хиймээр байна.

Г.Занданшатар: Гишүүд дэмжсэн, дэмжээгүй 6 гишүүн үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Санал хураалтын өмнө энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа 1 дүгээр сарын 7-нд төрсөн Улсын Их Хурлын гишүүн Долгорсүрэнгийн Сумъяабазарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс төрсөн өдрийн мэнд хүргэж, эрүүл энх, сайн сайхан аз жаргалыг хүсэн ерөөе.

Бусдад нь түрүүн мэнд дэвшүүлсэн юм.

Энэ Дондогдоржийн Эрдэнэбат гишүүний хэлсэн тэр Лувсанжав гуай тэр юуг анхаараарай. Хувьцаа эзэмшигчийн хувьд захиран зарцуулах чиг үүргийг Засгийн газарт өгөх нь гээд байна шүү дээ. Тэр чинь сан нь тусдаа. Тэгээд Улсын Их Хурлын юу яав гэсэн агуулгатай юм хэлээд байна шүү дээ. Төрийн эрх мэдлийн хуваарилалтын хувьд. Тэрийгээ зүгээр анхаараарай.

Тэр 1.2 дээр Цогзолмаа гишүүний хэлээд байгаа шударга хүртээмжтэй гэдэг зарчмыг хэлсэн.

1.3 дээр Оюунчимэг гишүүн Нямбаатар гишүүдийн хэлсэн саналууд байна. Энэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ганбат. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль зүйн хэлтсийн дарга Мягмар, өнгөрсөн юун дээр Орон нутгийн удирдлагын газрын дарга Зоригтбаатар нар байсан. Энэ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нийт сум суурин газрууд хот тосгон болж өөрчлөгдөх, аймгийн төвүүдийг хот болгож өөрчлөх асуудлуудыг оруулж ирээрэй гэж нэгдүгээр хэлэлцүүлгийн үед чиглэл өгсөн шүү дээ. Энийг дотроо анхаарч энэ чинь дагаж мөрдөх журмын тухай хуулиар 6 сардаа багтааж шийдүүлэхээр орсон байгаа шүү.

Ингээд санал хураалт явуулна.

Саяын найруулгын саналаар санал хураалт. Санал хураалтад 47 гишүүн оролцож, 29 гишүүн дэмжиж, 61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ бас нэлээд урт байгаа. Танилцуулахын тулд бүгдийг унших ёстой гэсэн байгаа.

Хоёр.Хавсралтын 2 дугаар бүлгийн 1, 2, 3 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах. /Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд хийсэн найруулгын засвар/

“1.Засгийн газрыг эмхлэн байгуулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

1.1.Сонгуулийн дүнгээр аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй тохиолдолд улс төрийн нам, эвсэл заавал олонхыг бүрдүүлж Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх шаардлагыг хуульчлах;

1.2.Ерөнхий сайд нь Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, зөвшилцөж чадаагүй тохиолдолд өөрөө өргөн мэдүүлэх зохицуулалтыг хуульчлах;

1.3.Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн дөрвөөс илүүгүй нь Улсын Их Хурлын гишүүн байж болох зохицуулалтыг холбогдох хуульд тусгах.

1.4.Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх зохицуулалтыг хуульчлах.

2.Засгийн газар танхимын зарчмаар, тогтвортой ажиллахтай холбоотой нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

2.1.Ерөнхий сайд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсаны үндсэн дээр Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах зохицуулалтыг хуульчлах;

2.2.Ерөнхий сайдыг огцруулах журам, Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох талаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах;

2.3.Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх асуудлаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд тусгах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2020 оны хаврын чуулган	<ul style="list-style-type: none">• Засгийн газрын тогтвортой ажиллах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;• Засгийн газар танхимаар ажиллах зарчимд нийцүүлэн Ерөнхий сайд бие даан танхимаа бүрдүүлэх зохицуулалтыг хуульчлах;

			<ul style="list-style-type: none"> • Ерөнхий сайд өөрт нь итгэл үзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хуралд оруулах зохицуулалтыг хуульчлах; • Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах хязгаарыг хуульчлах.
--	--	--	---

3. Ерөнхийлөгчид нэр дэвших насны босго, бүрэн эрхийн хугацааг нэмэх талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

3.1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаарыг өндөрсгөж, зөвхөн нэг удаа сонгогдох;

3.2.Ерөнхийлөгчид зөвхөн Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийнх нь хүрээнд тодорхой бүрэн эрх олгож байхаар зохицуулах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай; -Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль; /шинэчилсэн найруулга/ -холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	2020 он	<ul style="list-style-type: none"> • Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх; • Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан хүрээнээс халихгүй байх нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид оруулах; • Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрх олгох асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт. Нямбаатар гишүүн. Горимын санал.

Х.Нямбаатар: Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулж өгөөч.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох Нямбаатар гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 42 гишүүн оролцож 24 гишүүн дэмжиж 57.1 хувийн саналаар өмнөх саналыг хүчингүйд тооцлоо.

Энэ санал дэмжигдэж өмнөх санал хүчингүй болсон учраас дахин санал хураалт явуулна.

Санал хураалт. 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав.Хавсралтын 3 дугаар бүлгийн 1, 2, 3 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах. /Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд хийсэн найруулгын засвар/

“1.Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

1.1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институтээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох, гишүүдийг зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллуулах, Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгох журмыг хуулиар тогтоох;

1.2.Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах зохицуулалтыг хуульчлах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Шүүхийн захиргааны тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none">• Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдэд тавих болзол, шалгуур, тэдгээрийг сонгох, томилох, Зөвлөлийн даргыг сонгох журам;• Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг тодорхойлох;• Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах журам.

2.Шүүгчийн хариуцлагыг сайжруулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

2.1.Хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороог байгуулах, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, журмыг хуулиар тогтоох;

2.2.Шүүхийн сахилгын хороо нь хөндлөнгийн нөлөөллөөс ангид байж, төвийг сахиж хараат бусаар шийдвэр гаргаж, шүүгчийг сахилгын шийтгэлийн журмаар албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, сахилгын бусад шийтгэл ногдуулах замаар шүүгчийн ёс зүй, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2.3.Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид, нэр хүндтэй иргэд, хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтдээс нээлттэй нэр дэвшүүлэх замаар холбогдох институцүүдээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	- Шүүхийн сахилгын хорооны тухай хууль/анхдагч хууль/ - Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020 он	<ul style="list-style-type: none"> • Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн, гишүүдэд тавих болзол, шалгуур, бүрдүүлж байгуулах журмыг тогтоох; • Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх, зөрчлийн шинж байдалдаа тохирсон байх, давхардахгүй байх зарчмыг үндэслэн тодорхойлох; • Хорооны бүрэн эрх, үйл ажиллагааны болон сахилгын зөрчил хянан шийдвэрлэх журмыг хуульчлах; • Хорооны шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг гомдлын дагуу Улсын дээд шүүх эцэслэн хянах журмыг тогтоох.

3.Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд доор дурдсан чиглэл баримтална:

3.1.Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахдаа иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох үндсэн зарчимд нийцүүлнэ.

д/д	Хуулийн нэр	Хугацаа	Хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утга
1.	-Шүүх байгуулах тухай болон Шүүхийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт	2021 он	<ul style="list-style-type: none"> • Хүн ам, газар нутаг, шүүгчийн ажлын ачааллыг харгалзан тойргийн шүүх байгуулж болох үндэслэл, журмыг нарийвчлан тогтоох; • Шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, тойргийн зарчмаар шүүх байгуулах нь шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр чөлөөлөх, шилжүүлэх үндэслэл болохгүй байх зохицуулалтыг хуульчлах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт. 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль, тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт явуулъя. 65.9 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Нарантуяа гишүүнд Пүрэвдорж гишүүн уламжлаарай. Чиглэл өгч байгаа болохоос биш Үндсэн хуулийн үзэл баритлалыг дурдаж байгаа чиглэл өгч байгаа болохоос биш хашиж хааж байгаа зүйл биш.

Ингээд дараагийн асуудалд орно.

Дууны бичлэгээс буулгасан:

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ

ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА